

Нийгмийн тухай мэдлэг

БАГШ:Д.ОЮУН

Сэдэв 6: Төрийн тухай ойлголт болон сонгуулийн тогтолцоо

Сэдвийн зорилго:

Нийгмийн төрийн үүсэл хөгжил, үүсч хөгжихөд нөлөөлсөн хүчин зүйлс, түүний чиг үүрэг, хэлбэр зэрэг гол шинжүүдийн талаар цэгцтэй мэдлэг олгох. Мөн сонгуулийн үндсэн нөхцлүүд, системчлэл, давуу болон сул талын талаар мэдлэг олж авахад оршино.

Түлхүүр үгс:

- Төрийн үүсэл
- Төрийн чиг үүрэг
- Төрийн хэлбэр
- Төрийн дэглэм
- Мажоритор
- Холимог
- Пропорциональ

Төр, түүний үүсэл- онол

Төрийн үүслийн онолууд

- **Шашны онол:** бурханы зарлиг, элчийн үйл ажиллагааны бодит биелэл
- **Эцгийн эрхт ёсны онол:** Гэр бүлийн захирах, захирагдах ёсны үр дүн
- **Нийгмийн гэрээний онол:** Ард түмэн болон засаглалын хоорондын гэрээ
- **Нийгэм, эдийн засгийн онол:** Хүмүүс нэгдэж, гаршсан зүйлээ хийснээр хэрэгцээгээ ханган хөдөлмөрийн хуваарьт орж төр үүссэн
- **Ангийн онол:** Хөдөлмөрийн хуваарь, хувийн өмч бий болсоноор ангиудад хуваагдан, нэг анги нөгөөгөө албадан ноёрхсоноор үүссэн.
- **Хүчирхийллийн онол:** Төрийг дарангуйлагч нь харин арга хэрэгсэл нь эрх зүй гэжээ
- **Өв залгамжлалын онол:** Өөрийн гэсэн газар, баялагтай, хүчтэй хүмүүс хэсэг орон зайд ноёрхон төр үүссэн
- **Сэтгэл зүйн онол:** Хүний оюун ухаан, түүний асуудал шийдвэрлэх чадвар нь төрийг үүсгэсэн.
- **Органик онол:** Төрийг амьд биетэй адилтгах үзэл
- **Улс төрийн антропологийн онол:** Ангийн бус буюу экологийн, хүн ам зүйн, сэтгэл зүй зэрэг нь гол шалтгаан гэж үзсэн.

Төрийн хөгжлийн үе шат

- Түүхэн нийтлэг бүрэлдэн тогтсон үеийн төр
- Эртний грек, Ромоос дундад зууныг дуусах хүртэлх үеийн төр

- Орчин үеийн төр

Төр бол тодорхой хил хязгаарын доторх нутаг дэвсгэр дээр аж төрж буй хүмүүсийн нийтлэгийн өөртөө тогтнох эрхийн илэрхийлэл, өөрийгөө зохион байгуулах үндсэн арга мөн.

- ❖ Дотоод гадаадад бие даасан эрх эдлэж, үүрэг хүлээдэг байх
- ❖ Хил хязгаараар зааглагдсан нутаг дэвсгэртэй байх
- ❖ Өөрийн харъяат иргэдтэй байх
- ❖ Нутаг дэвсгэрээрээ заавал биелүүлэх хэрэгжүүлж байх
- ❖ Өөрийн оршин тогтнох эдийн засгийн үндсийг алба татварын замаар хангадаг байх
- ❖ Нийгэмд албадлага хэрэглэх эрхтэй байх, уг эрхээ хэрэгжүүлэх аппараттай байх

ТӨР ҮҮСЧ , ХӨГЖИХӨД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

- Янз бүрийн хүн ам үйлвэрлэлээ явуулж , хэрэгцээгээ хангах орон зайтай байх үүднээс нутаг дэвсгэрээ зааглах сонирхол
- Хүмүүсийн бөөгнөрөл, суурьшил бий болсон нь газар нутгийг эзэрхэх, угсаатны нийтлэг бүрэлдэх, улмаар төрийн салшгүй шинж
- хүн ам бий болох нөхцлийг бүрдүүлсэн байдал
- Нийгмийн томоохон тогтвортой бүлэг хүмүүсийн хэрэгцээ сонирхолд гол гол ялгаа бий болсон тул тэдгээрийн харилцааг зохицуулах шаардлага
- Улсын хүн амыг бүхэлд нь захирах, албадах замаар тогтвортой байдлыг хангах шаардлага
- Хөдөлмөрийн хуваарь, баялгийн хуримтлалд тулгуурласан нийгмийн бүтцийн өөрчлөлт бий болж нийгмийн дээд, доод, дунд, анги давхраа бий болсон явдал
- Хүн ам , өөрийгөө болон нутаг дэвсгэрээ гадны аюулаас хамгаалах сонирхол
- Хүчирхийлэл, нийгмийн гэрээ, бусдын туршлага
- загвар зэрэг хүчин зүйлс

Төрийн чиг үүрэг

- Дотоод чиг үүрэг
 - Улс төрийн
 - Эдийн засгийн
 - Эрх зүйн
 - Нийгмийн
 - Оюун санааны

- Гадаад чиг үүрэг

Улс орноо батлан хамгаалах
Дэлхийн улсуудтай хамтрах

Төрийн шинж

- Хүн ам

Тухайн улсад суугаа захирах ба захирагдах хүмүүсийн нэгдэл


- Нийтлэг эрх мэдэл

Улс төрийн эрх мэдлийн дээд хэлбэр нутаг дэвсгэр хүн амыг бүрэн хамардаг

- Нутаг дэвсгэр

Тухайн улсад хязгаарлагдаж буй хил хязгаар зааглагдаж буй газар

Төрийн хэлбэр



Төрийн байгууламжийн хэлбэр болон дэглэм

Ардчилсан бус Тоталитар	Бүх нийтээр хянан захирах дэглэм. Фашист, коммунист дэглэмүүд орно.
Ардчилсан бус Авторитар	Нэг буюу хэсэг хүмүүмсийн дарангуйлал ба ардчилсан ба тоталитар дэглэмийн завсрын бүс.
Ардчилсан либерал дэглэм	Хуулиар хориглоогүй бүхнийг зөвшөөрнө
Ардчилсан консерватив дэглэм	Төрийн нэр хүнд, уламжлалт үнэт зүйлийг хангадаг. Хүний салшгүй эрх болох өмчлөх эрхийг хүний эрх, эрх чөлөө нийгмийн дэг журмын баталгаа гэж үздэг.
Ардчилсан оклохрат дэглэм	Ардчилсан бус дэглэмээс ардчилсан болж буй улс орнууд багтана.
Орчин үе дэх ардчилсан хэв маяг	Эрх зүйн төр- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахын тулд эрх зүйт хуулийг мөрддөг. Социал төр- Тэгш бус нөхцөлийг бууруулах, нийгмийн хамгааллаар хангахад чиглэсэн.

Сонгууль

Үндсэн нөхцөл

- Сонголт хийх алтернатив боломжтой байх- 2 ба олон нэр дэвшигчээс сонгох боломж
- Сонгуулийн эрх хуульчлагдсан байх- Сонгох, сонгогдох эрх тэгш хангагдсан байх
- Сонгуулийн чөлөөт, ардчилсан зарчмыг баримтладаг байх

Чөлөөт, ардчилсан зарчмыг баримтладаг байх:

- Бүх нийтийн зарчим
- Чөлөөтэй сонгох
- Шууд сонгох
- Саналаа нууцаар гаргах
- Тэгш эрхийн зарчим



Мажоритар

- Харьцангуй олонх
Хамгийн олон саналаар
- ЭНГИЙН ОЛОНХ
50+1
- ДИЙЛЭНХ ОЛОНХ
60%-аас дээш санал

Холимог

- Мажоритар пропорцианаль хувилбаруудын зарчмуудаас авч хэрэглэнэ.
- Энэ нь парламентын суудлын тодорхой хэсгийг мажоритар тогтолцоогоор, үлдсэн хэсгийг пропорционал тогтолцоогоор хуваарилах арга юм.

Пропорциональ

- Нэрийн жагсаалтаар санал хураах
Намын авсан саналын тоогоор
- Шилжих нэг саналын арга буюу (Хейрийн)
Хувь хүний төлөө өгсөн саналын тоогоор

Сонгуулийн тогтолцооны онцлог, давуу болон сул тал

Онцлог- Хоёр буюу хүчтэй цөөн намын систем төлөвшихөд илүү нөлөөлдөг.

Мажоритар: Давуу тал

- Сонгогчид парламентын гишүүний үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага тооцох боломж илүү
- Улс төрийн намууд эвсэх , нэгдэх үйл явцад нөлөөлдөг
- Санал өгөх, хуваарилах зарчим энгийн ойлгомжтой.

Сул тал

- Сонгогчдын авсан санал , тэдгээрийн төлөөллийн харьцаа алдагдах
- Популистууд сонгогдох магадлал өндөр
- Парламентын гишүүн тойргийн сонгогчдоос хараат байдалтай
- Нутгийн хүнийг сонгох сэтгэлзүйн хандлага илүү
- Парламентийн гишүүн , нам хоёрын хоорондын хариуцлагын зарчим алдагдах магадлалтай

Сонгуулийн ТОГТОЛЦООНЫ ОНЦЛОГ, давуу болон сул тал

Онцлог- Олон намын систем, парламентын засаглал төлөвшихөд эерэг нөлөөтэй.


Пропорционал: Давуу тал

- Улс төрийн хүчний харьцааг парламентад зөв тусгах
- Санал болгон төлөөлөгдөх боломжтой
- Парламентын гишүүд улс төрийн намын өмнө хариуцлага хүлээх чадвартай байх
- Улс төрийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, түүний хариуцлага хүлээх чадварыг дээшлүүлэх

Сул тал

- Парламентад хэт олон намууд төлөөлөгдөх магадлалтай. (Гэвч босго тогтоох замаар түүнийг хязгаарлах боломжтой)
- Бие даасан нэр дэвшигчид сонгогдох боломж хязгаарлагдмал
- Орон нутгийн төлөөллийг хангах чадвар сул

Төр нь зайлшгүй, түгээмэл шинжтэй.
Албадлагын онцгой хэлбэр бөгөөд бие даасан
бүрэн эрхт тусгаар байгууллага мөн.





Хяналтын асуулт, даалгавар:

1. Тухайн нутаг дэвсгэр хил хязгаарт хамаарч буй зааглагдсан хэсгийг.....гэнэ.

- А. Эрх мэдэл
- Б. Сонгогдох эрх
- В. Төрийн нутаг дэвсгэрийн шинж
- Г. Төрийн нийтлэг эрх мэдлийн шинж

2. Мажоритар тогтолцооны шинж?


- А. Энгийн олонх
- Б. Санал болгон төлөөлөгдөх боломжтой
- В. Орон нутгийн төлөөллийг хангах чадвар сул
- Г. Олон намын давамгайлал

3. Улс орноо батлан хамгаалж гадаад улстай эдийн засгийн хамтын гэрээ хийх нь?

- А. Төрийн гадаад чиг үүрэг
- Б. Төрийн дотоод чиг үүрэг

Эх сурвалж:

1. “Нийгэм судлал” хичээлийн ерөнхий боловсролын сурах бичгүүд
2. Д.Буян “Нийгмийн тухай мэдлэг”. УБ., 2011
3. Орчуулсан Б.Батчулуун “Философи”. УБ., 2012
4. О.Пүрэв, С.Нямзагд, Р.Дарьхүү, Г.Сайнхишиг, Д.Буян, Т.Алтанцэцэг “Нийгмийн ухаан”. УБ., 2012
5. Б.Амгаланбаяр, Т.Сайхнаа “Хичээлүүдийн лавлах”. УБ., 2014



Анхаарал хандуулсанд баярлалаа.

